



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 24 өдөр

Дугаар А/862

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1, 4 дүгээр зүйлийн 4.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 99 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар “COVID-19”-ын цар тахалтай тэмцэх арга хэмжээний “Нэг цэгийн үйлчилгээний” бэлтгэл бэлэн байдлыг хангах, түргэвчилсэн тестийн нөөцийг бүрдүүлэхээр шинжилгээний оношлуур худалдан авах санхүүжилтэд нийт 120.0 сая төгрөг /нэг зуун хорин сая/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2. Тус арга хэмжээнд зарцуулах 120.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2021 онд батлагдсан төсвөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
12 дугаар сарын 24-ний өдрийн
А/863 дугаар захирамжийн хавсралт



СУМДЫН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДЛЫГ
ХАНГАХ ТҮРГЭВЧИЛСЭН ТЕСТИЙН НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭХ
АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТ

№	Хүлээн авах байгууллагын нэр	Нийлүүлэх байгууллагын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт дүн /мянган төгрөг/
1.	Аймгийн Онцгой байдлын газар	“Акютест” ХХК №24 гэрээ	10000	12000.00	120000.0
Нийт дүн			10000		120000.0

-oOo-